

2018 ОНД ТӨВ АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Дотоод зохион байгуулалтын чиглэлээр

Бүх ажилчидтай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж ажил үүргийн хуваарыг шинэчилж, жил, сар, улирлын төлөвлөгөөг баталгаажуулан багш дасгалжуулагчдын секц дугуйлангий төлөвлөгөө, хуваарийг баталгаажуулан ажилласан.

2018 оны уралдаан тэмцээний нэгдсэн заавар удирдамжийг батлан сумдад хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2018 онд засаг даргатай байгуулах гэрээг 5 зорилт 16 хэрэгжүүлэх арга хэмжээ, тусгай захилгат 25 бүтээгдэхүүнтэй гэрээг байгуулж 2018 оны үр дүнгийн гэрээ 92.2 % “А” үнэлгээтэй дүгнэгдсэн.

2018 оны ажлаараа аймгийн нийгмийн салбарын шилдэг байгууллагаар шалгарч, 2018 онд төрийн албан хаагчдын спортын анхдугаар их наадмыг зохион байгуулан явуул энэ арга хэмжээ нь шилдэг онцлох ажлаар шалгарч “Цом” өргөмжлөлөөр шагнагдсан.



- Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2 дахь үе шатны төлөвлөгөөг 3 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталуулан
- НБТ-ын чиглэлээр 8 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 70 % - 4
 - 100 % - 4 биелэлт 81.25 %
- Их спортын чиглэлээр 8 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 70 % - 4
 - 100 % - 4 биелэлт 85 %
- Олимпийн танхим, материаллаг баазыг бэхжүүлэх 2 хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт
 - 70 % - 1
 - 100 % - 1 биелэлт 85 %-тай хэрэгжиж байна.
- 3 зорилт 18 арга хэмжээний биелэлт
 - 100 % - 8
 - 70 % - 10 биелэлт 83.33 % (4.36)-тэй хэрэгжүүлэн ажилласан.

Төв цэнгэлдэх хүрээлэнд хөл бөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, волейбол, гүйлт алхалт, дугуйн 500 м-ийн асфалтан зам, шагайн харвааны асар, үндэсний сурын талбайг 509.219.075 төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулж ашиглалтанд оруулж ХЦСургууль, Алтанбулаг, Аргалант, Баянхангай Эрдэнэсант, Угтаалцайдам сумд биеийн тамирын гадаа талбайгаа шинэчлэн тохижуулсан



Олон улсын хөл бөмбөгийн холбооны дэмжлэгээр 850.000 долларын хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн олон улсын стандартын талбай, Аргалант, Эрдэнэсант сумдад спорт заал ашиглалтанд орсон.



Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд үндэсний спортын 16 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 27 сумын 2373 хүн хамрагдаж, үндэсний спортын VI-р их наадмын шигшээ тэмцээнд 53 тамирчин оролцож Алт-7, Мөнгө-16, Хүрэл-19, бүгд-42 медаль хүртэж, спортын мастерын болзлыг 3, спортын дэд мастерын болзлыг 3 тамирчин ханган биелүүлж, байгууллагын нэгдсэн дүнгээр II-р байр эзэлж, цом өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан



МУ-ын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан Иргэдийн спортын их наадмын шигшээ тэмцээнийг 2018 оны 10-р сарын 06-нд зохион байгуулж 13 сумын эр 27, эм 17 нийт 44 багийн 374 тамирчин оролцож спортын 3-н төрлөөр өрсөлдлөө.



Олимпзм ба бие бялдрын хүмүүжил сэдэвт болзолт уралдааны хүнээннд зохион байгуулагдаж буй Төв нутгийн олимпийн медальтнуудын бахархал аяны зохион байгуулж 27 суманд цом, дэвтрийг аялуулсан.



2018 оны спортын шилдэгүүдийг шалгаруулах ёслолын ажиллагааг зохион байгуулж спортын 13 төрлөөр улсын аварга шалгаруулах тэмцээнд медаль байрт шалгарсан 130 тамирчинд мөнгөн урамшуулал олгож шилдэгүүдээ шалгаруулсан.



Хоёр. Сургалт сурталчилгааны чиглэлээр

ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагаас зохион байгуулсан БТСГ-ын арга зүйчид, клуб, хамтлагийн гишүүдийн сургалт семинарт арга зүйч Л.Хишигдэлгэр, Баянчандмань сумын НБТ-ын арга зүйч А.Билгүүн, шилдэг жү-до клубын дасгалжуулагч Ц.Батзаяа нар хамрагдлаа.



Аймгийн Прокурорын газраас 3 хүний бүрэлдэхүүнтэй гэр бүлийн хүчирхийлэл, авилгалын тухай хуулийг сурталчилах сургалтыг зохион байгуулж тус сургалтанд 20 ажилтнаас, 14 албан хаагч хамрагдсан.



Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд Монголын Аутизмын холбоо, Дамын холбоо, Монголын Тусгай Олимпын хорооны сургагч багш, удирдах ажилтнуудын үйл ажиллагаа, өнөөгийн байдлын талаарх сургалтанд НБТ-ын арга зүйч Э.Сайнзаяа оролцлоо.



Таны эрүүл мэнд- Таны гарт аяны хүрээнд “Цэвэр гар эрүүл амьдралын жор” сэдвийн дор Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн сургагчдаар гар угаах зөв хэвшлийг сургах зорилгоор сургагч баг нараар байгууллага дээрээ хичээл заалган БТСГ-ын 8 хүн, үндэсний бөхийн өсвөр үе, залуучууд, насад хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор бэлтгэл сургуулилт хийж буй тамирчид 6 нийт 14 хүн сургалтанд хамрагдан гарын авлага тараах материалыг өгсөн.




БСШУСЯ, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ хамтран МУ-ын ерөнхий сайдын ивээл дор “СПОРТ БА ХӨГЖИЛ” биеийн тамирын улсын 4-р зөвлөгөөнийг УБ хот төрийн ордонд зохион байгуулж зөвлөгөөнд Төв аймгаас 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцсон



Хэнтий аймагт зохион байгуулагдсан Биеийн тамир, спортын тухай хууль, эрх зүйн баримт бичгшүүд, биеийн тамир спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах, бодлог, цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах нь сэдэвт 2 хоногийн сургалт семинарт дасгалжуулагч, арга зүйчид хамрагдлаа.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн пара спортын хөгжил сэдэвт сургалтын Аймгийн ХХҮГ-тай хамтран зохион байгуулж нийт 34 хүнийг хамруулсан.



Төв аймгийн Заамар суманд нийгмийн салбарын байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 147 хүн оролцсон. 1 а ангийн сурагчдын цүнхний жингийг судалгаанд авч 24-н сурагч хамрагдсанаас 4-н сурагч хэвийн 18-н сурагч илүү хүнд жинтэй цүнх үүрч байна.Цүнхийг яаж тохируулж үүрэх талаар биеийн тамирын багш, бага ангийн багш, эцэг эхчүүд, сурагчдад зөвлөмж өгч, гарын авлага тараах материал өгсөн.



БТ-ын багш нарын сургалт семинарыг БСУГ-ын хурлын танхимд зохион байгуулж 23 сумын 35 багш хамрагдан сургалтанд ТСБТСДуС-ийн захирал, доктор профессор /РН.ДЧ.Зоригтбаатар, ТСБТСДуС-ийн багш, магистр Х.Гэрэлцогт, Анагаах ухааны доктор профессор Аврага БТДС-ийн гүйцэтгэх захирал Г.Сүхбат, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын ахлах мэргэжилтэн Х.Отгонбаатар, Сөүл олимпийн зөвлөлийн дарга Ц.Чанцал, БСУГ-ын мэргэжилтэн Ч.Цэцгээ нар оролцож хичээл заалаа.



Алтанбулаг суманд зохион байгуулагдсан нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр багуудын ИНХ-д оролцонзургаан байгуулагад ажлын байрны дасгалын плакад, гарын авлага, тараах материалыг, ЕБС-д чөлөөт бөхийн дасгалжуулалт, спортын сэтгэл зүй, үндэсний бөхийн тухай нийт таван номыгөгч, сорил авах аргачлал, биеийн жингийн индексийг гаргах талаар заавар зөвлөгөөг өгсөн.



Хөдөлмөрийн хууль тогтоомжийг сурталчилах, аяны хүрээнд МТТеатр, Музей, Номын сан, БТСГ-ын Газар хамтран хуулчдын зөвлөлийн тэргүүн Б.Баярмагнайгаар хөдөлмөрийн тухай хууль, зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгуулж манай байгууллагын 14 хүн хамрагдсан.



Сагсан бөмбөгийн багш дасгалжуулагчдын сургалт семинар Орхон аймагт болж дасгалжуулагч Д.Эрдэнэбаатар хамрагдлаа.



Гурав. Нийтийн биеийн тамирын чиглэлээр зохион байгуулагдсан ажил

Нийтийн биеийн тамиры хөгжүүлэх зорилгоор Аймгийн ЗД-ын захирамжаар 7 хоног бүрийн Лхагва гаригийг “Нийгмийн эрүүл мэндийн өдөр” болгож, нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг Аймгийн хэмжээнд 24 удаагийн алхалтыг хийсэн бөгөөд энэ хугацаанд Зуунмод сумын 62 аж ахуйн нэгж, байгууллагын 5500 орчим иргэд, 26 сумын 4300 гаруй иргэдийг хамруулсан бөгөөд давхардсан тоогоор 10 мянга орчим иргэн алхжээ. Төрийн албан хаагчдын спортын анхдугаар их наадмын бүс, шигшээ тэмцээнд 4.098 хүн иргэдийн спортын наадмын бүс, шигшээ тэмцээнд 1.218 хүн, Үндэсний спортын VI их наадмын бүс шигшээ тэмцээнд 2373, нийт НБТ-ын чиглэлээр 362 арга хэмжээнд 52.986 хүн хамрагдсан. Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн судалгаанд 43.801 хүн хамрагдаж, зохих түвшинд 18.922 хүн буюу 43.2 хувь нь хүрсэн. Заамар, Сүмбэр сумдад сорилын баг хамтран ажиллаж, 269 хүнээс сорил авч, спортын 5 төрлөөр уралдаан, тэмцээн зохион байгуулсан.

Ахмадын хороо, Батсүмбэр сумын ахмадын хороотой хамтран ахмадуудын дунд дуу, бүжгийн цэнгүүн өдөрлөгийг зохион байгуулж 4 багын 120 гаруй ахмадууд оролцсон.



Ахмадын баярыг угтаж Зуунмод сумын 6-н багийн ахмадуудын дунд граунд гольфийн тэмцээнийг зохион байгуулж 6 багийн 28 ахмад



Нисэх онгоцны буудлын ажилчдын Алтан намар тэмцээн зохион байнгуулагдаж 9 багийн 198 хүн спортын 5 төрлөөр



Мэргэшсэн нятлан бодогчтой байгууллагуудын дундах волейболын тэмцээнийг зохион байгуулж 13 багийн 100 гаруй тамирчид



Хүүхдийн эрхийн хамгаалах өдрөөр 13-14 насны тамирчдын дунд зохиогдсон 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнд охидын 8, хөвгүүдийн 12 багийн 78 тамирчин



Холбоочдын баярт зориулсан спортын баг наадмыг зохион явуулж 7 багийн 90 гаруй тамирчидыг



“Шилдэг хос” шалгаруулах” цэнгээнт бүжгийн тэмцээнийг зохион явуулж 11 сумын 29 хос ба 58 бүжигчид



Сүмбэр суманд Хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг 5-н сумын 5-н багийн дунд 4-н төрлийн тэмцээнд 122 хүн оролцсон.



Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн уламжлалт тэмцээнийг зохион байгуулж 6 багийн 34 тамирчин



“Хөдөлгөөн эрүүл мэнд -2018” өдөрлөгийг Заамар суманд Аймгийн Ахмадын хороотой хамтран зохион явуулж 9-н сумын 10-н багийн 230 тамирчин спортын 4-н төрлөөр



“Ланс-2018” Ланс уулыг гороолох явган аялалыг Аймгийн Дашчойнхорлон хийд, Аймгийн ахмадын хороотой хамтран зохион явуулж 5-н багийн 38 ахмад



Татвар төлөгчдийн өдөр зориулсан албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн дунд Аймгийн Татварын Хэлтсээс зохион байгуулсан сагсан бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 16, эмэгтэй, 9 багийн 163 тамирчин



Зуунмод Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилчин албан хаагчдын дундах тэмцээнийг 4 төрлөөр зохион явуулж 5 багийн 40 гаруй хүн



Цагаан сарын баяр болохтой холбогдуулан Аймгийн Цагдаагийн газраас дээлтэй Монгол өдөрлөг болж 64 бөхийн барилдааныг зохион байгуулсан



Зуунмод сумын ЗДТГ-ын ажилчид, ИТХ-ын тэргүүлэгчдийн дунд зохиогдсон спортын 5-н төрөлт тэмцээн зохион байгуулагдан 8 багийн 120 хүн хамрагдаж тэмцээний нээлтийн ажиллагаан дээр бүх хүн ажлын байрны дасгалыг хийснээр тэмцээний онцлог байлаа.



Дөрөв. Их спортын чиглэлээр зохион байгуулсан ажил үйлчилгээ

ААШТ өсвөр үе, залуучууд-29, Насанд хүрэгчид-17, Ахмад-8, Үндэсний спортын-16, нийт 70 арга хэмжээнд 17,357 хүн хамрагдсан. Өсвөр үеийн шигшээ багийг спортын 13 төрлөөр 160 тамирчинтай хичээллүүлж, шатрын танхим 8.2 сая төгрөгийн хандив тусламжаар байгуулсан. Шигшээ багийн тамирчид ОУ, УАШТ болон нэрэмжит тэмцээнээс: 108 алт, 89 мөнгө, 127 хүрэл, нийт 324 медаль авч СМ 3, СДМ 3 төрөн гарч тэшүүрийн тамирчин улсын рекорд дээд амжилтыг шинэчлэн тогтоосон

Зуунмодны хүчтэн пауэрлифтингийн тэмцээнийг зохион байгуулж 8 байгууллагын 80 гаруй тамирчид оролцсон.



Үндсэн хуулийн өдөрт зориулсан үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж 32 бөх барилдлаа.



АБТА, БТТА СМ Л.Нямцэрэнгийн нэрэмжит аймгийн аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээн Төв аймгийн Алтанбулаг суманд зохион байгуулагдан 2 сумын 30 гаруй тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.



2018 оны өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн ААШТ амжилттай зохион байгуулагдан 14 сумын 19 байгууллагын өсвөр үе 231, залуучууд насанд хүрэгчид 40 тамирчин оюун ухаанаа сорин өрсөлдсөн



МУ-ын гавъяат дасгалжуулагч, улсын арслан Ө.Эрдэнэ-Очирын нэрэмжит өсвөр үеийн чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж 14 сумын 17 байгууллагын 230 гаруй тамирчид хөвгүүд 12, охид 8 жинд, МУ-ын гавъяат тамирчин, ардын багш, улсын харцага, олимпийн наадмын хүрэл медальт Д.Сэрээтэрийн нэрэмжит залуучуудын чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж 14 сумын 80 гаруй тамирчид хөвгүүд 5, охид 5 жинд хүч чадлаа сорин өрсөлдлөө.



Баянчандмань сумын нэрэмжит ширээний теннисний ААШТ Баянчандмань суманд болж Баянчандмань, Батсүмбэр, Жаргалнат, Угтаалцайдам, ХЦС, 5-р сургуулийн 119 тамирчид оролцлоо.



Аймгийн аварга шалгаруулах Зуунбуудалт даамын тэмцээнийг зохин явуулж 8-н сум сургуулийн 130н өсвөрийн тамирчин хүүхэд, насанд хүрэгчид 26-н тамирчинд оролцсон.



МУ-ын гавъяат дасгалжуулагч, улсын арслан Л.Сосорбарамын нэрэмжит жү-до, МУ-ын гавъяат тамирчин Г.Үүрцолмонгийн нэрэмжит самбо бөхийн өсвөр үеийн ААШТ-ийг зохион явуулж 16 сумын 330 гаруй тамирчид оролслоо.



Зуунмод сумын ЕБС-ын дунд сурагчдын сагсан бөмбөгийн лигийн аварга шалгаруулах тэмцээнийг 1 сарын хугацаанд зохион явуулж 114 сурагч оролцон шигшээ тоглолтыг зохион байгууллаа.



Төв аймгийн Дэлгэрхаан сумын харъяат МУ-ын Гавъяат тамирчин Ц.Шаравжамцын нэрэмжит 2018 оны өсвөр үеийн ААШ сагсан бөмбөгийн 9 дэх удаагийн

тэмцээн зохион байгуулагдаж 18 сумын 23 байгууллагын 93 багийн 651 тамирчид хамрагдаж 3 насны ангилалаар өрсөлдлөө.



Хөнгөн атлетикийн өсвөр үеийн 2018 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж 11 сумын 15 байгууллагын 150 тамирчин оролцсон.



Аймгийн ЗД-ын ивээл дор зохион байгуулагдсан цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн ААШТ зохион байгуулагдаж 29 цэцэрлэгийн 350 тамирчин оролцлоо.



Аймгийн үндэсний спортын VI их наадмын шагайн харвааны аварга шалгаруулах тэмцээн болж 8 сумын 12 багийн 92 харваач оролцсоноос МУҮДМ 4, МУДМ-1, МУХМ-2, МУМ-3, ХМ-3, Аймгийн гоц мэргэн 22 харваач оролцсон.



Төрийн албан хаагчдын спортын анхдугаар наадмыг Эрдэнэ, Лүн, Баян-Өнжүүл, Баянчандмань, Угтаал, Зуунмод гэсэн 6 бүсэд зохион байгуулж шигшээ тэмцээнийг спортын 8 төрлөөр зохион байгуулж 4.098 хүнийг хамруулсан.



Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд сурын харвааг Үндэснийсур, Урианхай сур, Буриад сур гэсэн 3 төрлөөр зохион явуулж 5 сумын 60 гаруй тамирчид, ширээний шагайг зохион явуулж 56 тамирчин оролцлоо.



Үндэсний спортын VI их наадмын хүрээнд зохион байгуулагдсан жороо морины уралдааныг Батсүмбэр суманд зохион байгуулж 8 сумын 18 морь оролцсон



“Төв түмний цэнгэл 2018” баяр наадмыг анх удаа Баянцогт суманд зохион явуулж сурын харваанд 30 харваач, шагайн харваанд 172 харваач, хурдан морины уралдаанд 352 нийт 650 хүн хамрагдсан.



Төв аймгийн Баян-Өнжүүл сумын ЗДТГ- аймгийн шагайн товчоотой хамтран Сөдөтын тойрмыг Баян-Өнжүүл суманд зохион байгуулж 25 багийн 200 гаруй харваачид хамрагдсан.



Үндэсний бөхийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Эрдэнэсант суманд зохион явуулж 8 сумын 72 тамирчин оролцлоо.



МУ-ын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан Иргэдийн спортын их наадмын шигшээ тэмцээнийг зохион байгуулж 13 сумын эр 27, эм 17 нийт 44 багийн 374 тамирчин оролцож спортын 3-н төрлөөр өрсөлдлөө.



Монгол бахархалын өдөрт зориулсан “Зуунмодны цом 2018” шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулж 15 багийн 105 харваачид оролцсон.



АБТА, БТТА, Волейболын спортын мастер С.Алтанхуягийн нэрэмжит өсвөр үеийн ААШ волейболын тэмцээнийг Батсүмбэр суманд А.Эрдэнэбат захиралтай ЕБС-тай хамтран зохион явуулж 32 багийн 256 тамирчин хамрагдан оролцлоо.



Монгол улсын их хурлын даргын ивээл дор шинэ үндсэн хууль батлагдсан өдөрт зориулан зохион байгуулсан шатар сонирхогчдын Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг Аймгийн ИТХ, БТСГ, Аймгийн шатрын холбоо хамтран амжилттай зохион явуулж 12 сумын 32 тамирчин хамруулсан.



УИХ-ын гишүүн, Батлан хамгааланы сайд Н.Энхболдын нэрэмжит “Атарчин-2018” спортын наадам зохион байгуулагдаж 24 сумын 220 гаруй тамирчид спортын 5 төрлөөр өрсөлдлөө.



Тав. Онцлох ажил

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Төв цэнгэлдэх хүрээлэнд хөл бөмбөг, сагсан бөмбөг, софт теннис, волейбол, гүйлт алхалт, дугуйн 500 м-ийн асфалтан зам, шагайн харвааны асар, үндэсний сурын талбайг 509.219.075 төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр байгуулж ашиглалтанд оруулж ХЦСургууль, Алтанбулаг, Аргалант, Баянхангай Эрдэнэсант, Угтаалцайдам сумд биеийн тамирын гадаа талбайгаа шинэчлэн тохижуулсан



Олон улсын хөл бөмбөгийн холбооны дэмжлэгээр 850.000 долларын хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн олон улсын стандартын талбай, Аргалант, Эрдэнэсант сумдад спорт заал ашиглалтанд орсон.



УРАЛДААН ТЭМЦЭЭН

Аймгийн үндэсний спортын VI их наадмын хүрээнд үндэсний спортын 16 төрлөөр арга хэмжээ зохион байгуулж, 27 сумын 2373 хүн хамрагдаж, үндэсний спортын VI-р их наадмын шигшээ тэмцээнд 53 тамирчин оролцож Алт-7, Мөнгө-16, Хүрэл-19, бүгд-42 медаль хүртэж, спортын мастерын болзлыг 3, спортын дэд мастерын болзлыг 3 тамирчин ханган биелүүлж, байгууллагын нэгдсэн дүнгээр II-р байр эзэлж, цом өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан



Төрийн албан хаагчдын спортын анхдугаар их наадмыг спортын 8 төрөл /сагсан бөмбөг, волейбол, шатар, ширээний теннис, шагайн харваа, граунд гольф, аэробик, хөл бөмбөг/ зохион байгуулж 4.098 хүнийг хамруулсан.



“Үндэсний цом-2018” улсын хэмжээний тэмцээнийг зохион байгуулж 17 аймгийн 352 тамирчин оролцсон



“Жаргалант-2018” өсвөрийн цанычдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 02-р сарын 22-25-ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант суманд зохион байгуулагдаж 12 аймаг, 2 дүүргийн 20 багийн 164 тамирчин оролцож 96 багц медалын төлөө өрсөлдлөө. Манай баг тамирчид 13 алт, 7 мөнгө, 2 хүрэл медаль, багийн дүнгээр алт нийт 23 медаль хүртэж 1 спортын мастер төрөн гарсан.



Төв аймгийн Алтанбулаг сумын харьяат Ази тивийн аварга, ОУХМ, улсын заан Рөнцэнхүүгийн Гансүхийн нэрэмжит бөхийн чөлөөт барилдааны 2018 оны залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 2018-04-07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 10 аймгийн 4 дүүргийн 30 багийн 350 гаруй тамирчид оролцсон



Олимпзм ба бие бялдрын хүмүүжил сэдэвт болзолт уралдааны хүнээннд зохион байгуулагдаж буй Төв нутгийн олимпийн медальтнуудын бахархал аяны зохион байгуулж 27 суманд цом, дэвтрийг аялуулсан.



АЙМГИЙН БТС-ЫН ГАЗАР